

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Я.Амарсайхан	Дугаар	L139
Оршин суугаа аймаг	Сүхбаатар	Оршин суугаа сум	Баяндэлгэр
Төрсөн газар	Баяндэлгэр	Төрсөн он	
Ажил мэргэжил	Хийдийн хамба лам		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Байшинтын хийд, Бударганын хийд, Нарангийн хийд, Өгөөмөрийн хийд, Ширээтийн хийд	Сүм хийдийн дугаар	СББД 021, СББД 025, 023, СББД 027 СББД 023, СББД 027
Одоогийн сүм хийд	Гандандамбадаржаалин	Сүм хийдийн дугаар	СББД 029
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 8-р сарын 12	Ярилцлага авсан хүн	Ж.Одгарьд

Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сумын Байшинтын хийд, Бударганын хийд, Нарангийн хийд, Өгөөмөрийн хийд, Ширээтийн хийд Гандандамбадаржаалин хийд

Баяндэлгэр сумын нутагт буян номын үйл ажиллагаа явуулж байсан сүм хийд, дацангуудын тухайд Байшинтийн хийд 4 дацантай 1000 шавьтай Дарьганга хошууны 13 хийдийн хамгийн том нь байжээ. Одоо тус хийдийн түүрийн орчим дэргэд Чойр дацан, Дүйнхэр дацан, сумын жасуудыг шинээр сэргээн байгуулж жил бүр хаврын тэргүүн сарын шинийн хоёронд сан тавьж Дором бүл өргөнө. Хаврын адаг сарын 22, намрын эхэн сарын 22-оос Санжид монломын хурлыг 5 яамлан хурж байна. Мөн шаардлагатай үеүдэд чогчин уншлага уншиж сүсэгтэн олны хүсэлтээр айлтгал үйлддэг юм. Жил бүр Их уулаа тахидаг.

Ширээтийн хийд 400 гаруй шавьтай Дарьганга хошууны хамгийн гоёмсог хийд байжээ. Одоо тус хийдийн суурин дээр 1990 онд Байшинтийн хийдийн гавж лам А.Дамба ахмад лам Цэдэнлхаам хамт Ширээтийн хийдийг дахин сэргээн санаачлан үүсгэн байгуулжээ. Тус хийдэд өдөр бүр чогжин хурж Их хөлгөн судруудаас аваад 150 гаруй ном судруудыг сүсэгтэн олны хүсэлтээр айлдаж байна. ширээтийн Баян-овоог жил бүр тахидаг.

Цагаан худгийн хийд сүм Бадрах уулаа тахидаг Онгон Баяндэлгэр сумын заагийн 300-аад шавь нартай байнгийн чогжин хурдаг жижиг сүм байсан гэдэг.

Бударгана усны сүм Нартын (Улаан уул)уулын энгэрт Нартын уулаа тахидаг 300-аад шавь сүсэгтэнтэй жижиг хийд байсан. Өгөөмөрийн хийд Баяндэлгэр сумын баруун урд баруун талыг хөмөрсөн Баян өгөөмөр овоог тахидаг мөн 300-аад лам хуврагтай жижиг хийд байжээ.

Нарангийн сүм-Баяндэлгэр сумын баруун урд, урд нурууг даган байрладаг. Ард сүсэгтнийг шүтдэг 300-аад лам хуврага сүсэгтэн жижиг хийд байсан ба Наран овоо Дөхөмийн баян овоо тахидаг байжээ.

Ламтаны нүүдэллэн хурал ном хурдаг Лагай, Өгөөмөр, хавцалын Эрдэнэ толгой зэрэг хийд сүмүүд байсан ба одоо ч түүр ором нь байна. Ламтан гэгээн Дарьгангын Алтан овоог жил бүр очиж тахидаг эзэн лам нь байсан гэдэг. Алтан овоог тахихаар явахдаа Өгөөмөр,

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Өлзийт хоолой, Эрдэнэ толгой, Байшинт, Сайн салаа гэх мэт газруудаар байнга буудал хоноглож хурал ном үйлдэж уул усаа аргадаж явдаг гэлцдэг.

Дарьгангын хошууны Байшинтын хийдийн товч түүх танилцуулга:

Байшинтын хийд Дарьганга хошууны гол сүм бөгөөд тэр үеийн Дарьгангийн 13 хийдийн хамгийн том нь. 1000 шавьтай Богд эзэнд мэдэлтэй, тамгатай, чийга ямпайтай, Чойр, Зурхай, Дүйнхор, Манба дацан болон бусад олон жижиг сүм дацантай байжээ. Мөн 4 м орчим өндөр сэнжит цагаан суварга, жасын олон байшингууд, лам багш нарын орон байшингууд, хоёр гэр хороотой байжээ. Сүм дотор тус бүрдээ чулуун шавар хашаатай, тэг гортигтой, дотор гаднаа хоёр худагтай, тохижилт байршил сайтай том хийд байсан бөгөөд хурал номын бүх уншлага судар номууд уншдаг. Жил бүр цам гарч, Майдаг эргэдэг. Сар бүр ба тухайн үеийн шаардлагаар Дүгжив балин залж, Чойжоо тахидаг. Мөн сор залах, мам залах гэх мэтчилэн шашны бусад үйл хийдэг байсан гэдэг. Шашин номын хэрэгсэл бурхан тахил, бүрээ бишгүүр хөгжим бүжгийн хэрэгсэл ихтэй байсан байна. Жил бүр Их уулын онгон шүтээнийг тахиж морь уралдаж бөх барилдаж наадам хийдэг байсан байна. 1930-1940 -өөд оны үед уншлага сайтай олон шавь нар байснаас Гандантэгчилэн хийдийн тэргүүн хамба Гомбожав гавж, Хаян хамба, дооромбо Лувсан-Осор, Ө.Лувсан-Иш, Ө.Лувсанзундуй, Сэрдамба, Жамбалнямбуу, гавж А.Дамба, Адаа Лувсанзундуй, Наваанжамъян, унзад Б.Давхай, О.Загдхорлоо, Ба.Сэрдамба, зурхайч Давагсүндэл, Содов, С.Чогдов, Лувсансодов нарын хүмүүс байгаад 1936-1937 он ба сүүлчийн их баривчлагаанд явцгаагаад ихэнх нь ирээгүй юм гэсэн. Зарим лам нар нь ирээд 1990 он хүртэл энх тунх байгаад насан эцэслэцгээжээ. Үүнээс гэвэл А.Дамба, унзад Давхай, Загдхорлоо, Наваанжамъян, О.Лувсанзундуй, М.Лувсанзундуй нар нь бурхан номынхоо ажлыг хийж сүм хийдээ сэргээн босголцож явсан. Байшинтын хийдийн гол томоохон хурлуудад Цагаан худаг, Ширээт, Бударгана ус, Өгөөмөр, Хавирга, Овоон сүм, Бөөрийн сүм хийдүүдээс лам нар олноороо оролцон ном хаялцдаг байсан гэдэг. Мөн ойрын сумуудын сүсэгтэн олон цам, Майдар үзэж, хурал номд даган баясаж, шавь ордог байжээ. Байшинтын хийдэд байнга 400-500 лам хурдаг, өвөл зуны цагт ээлжээр чөлөө авч хөдөөлдөг байсан гэдэг. Байнга суудаг өвгөчүүл лам нар олон байсан учир жасаас өвлийн идэш, сүү цагаан идээ, будаа гурил өгдөг байсан гэдэг.